

ЦАХИМ ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА МОНГОЛД

Б.Үүрийнтуяа*

*Олон Улсын харилцааны магистр

Түлхүүр үгс: нийгмийн сүлжээний сайтууд, олон нийтийн харилцаа, twiplomacy, жиргээний дипломаси, цахим дипломат ажиллагаа, twitter diplomacy дижиталчлал, цахимжилт


Одоогоос тав орчим жилийн өмнө эрчээ авч эхэлсэн Аж үйлдвэрийн хувьсгал бүх салбарт нэвтэрч эхэлснээр хэн ч энэ трендээс ангид үлдэхгүй нь тодорхой болсон (Corneliu Bjola & Marcus Holmes, 2015). Дипломат ажиллагаанд ч байр сууриа бататгаж буй тул салбарынхан үүнийг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаагаа ирээдүйн хэлбэрт хувьсгахаас өөр аргагүй болж байгаа юм (Corneliu Bjola & Marcus Holmes, 2015).

Цахимжилтын үр нөлөөгөөр өнөө цагийн дипломат ажиллагаанд олон нийтийн нийгмийн сүлжээ гол гүйцэтгэгч нь болжээ. Цахим дипломат ажиллагааны гол үүрэг гүйцэтгэгч нь Твиттер бөгөөд дэлхийн томоохон удирдагчдын дуу хоолойгоо, улсынхаа бодлогоо бусдад түгээдэг чухал хэрэгсэл болсон (Corneliu Bjola & Marcus Holmes, 2015).

Масс үйлдвэрлэл, Фордын ажлын найман цагийн загварчлалд суурилсан эдийн засгийн боломж,

бүтээмж шавхагдсан нь цахим шилжилтийн эхлэлээс ажиглагдах болсон. Элон Маскийн “Space X” хөтөлбөр, дэлхийн нийтэд интернэтийг үнэгүй болгох хиймэл дагуулуудын туршилт, сансарт байрлах нарны эрчим хүч ашиглах томоохон станцууд хэмээн ярьж буй энэ цаг үед дэлхий нийт улам л технологижих үйл явцад буцах боломжгүйгээр орлоо.

“Дижитал шилжилт бол хувирч өөрчлөгдөж буй технологи, үйл явцын тусламжтайгаар илүү инновацилаг, уян хатан бизнесийн болон үйл ажиллагааны загварыг бий болгох эрэл хайгуул” гэж Microsoft компанийн Монгол дахь түнш Леонид Шугуров тодорхойлжээ (business.mn). 2016 оны Дэлхийн эдийн засгийн чуулганаас хойш бүгд дижитал шилжилт гэх болов. Гэхдээ энэ процесс интернэт бий болсон цагаас хойш аажмаар байр сууриа бататгаж ирсэн (Mongolian Economy, 2016). Харин олон нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нь Дэлхийн эдийн засгийн форумын үүсгэн, зохион байгуулж эхэлсэн эрхэм Аж үйлдвэрийн хувьсгал IV гэж тодорхойлсноор энэ шилжилт бидний амьдралын нэг хэсэг гэгдэх боллоо.



Зураг 1. Twiplomacy гэх нэршлийн угшил, ORF(Observer Research Foundation).

Бүтээмж гэх ойлголт олон нийтийн амьдралд хөл тавьсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэх шинэлэг буюу инновацилаг аргыг олон улс эрэлхийлэх болсон. Энэ хандлага дэлхийн эдийн засгийн эко системийн бүх салбарыг хамарч дипломат ажиллагаанд ч мөн нэвтэрч, нутагшиж буйг онцлох цаг болжээ. Үүнээс улбаалан цахим дипломат ажиллагаа гэх нэршил гарч, олон хэлбэрт дижиталчлал өнөө цагийн дипломат ажиллагаанд сошиал медиа хэлбэрээр түгээмэл ашиглагдаж байна.

Сошиал медиагийн харьцангуй албаны гэгдэх Твиттерийг ашиглан дипломат харилцаа өрнүүлж twiplomacy гэж буй ч энэ нь зөвхөн жиргээ гэсэн ойлголт биш. Facebook тэргүүтэй сошиал платформыг багтаах энэ ойлголтод өдгөө НҮБ-ын гишүүн орны 98 хувь нь нэгдсэн гэх статистик бий. Зөвхөн энэ тоо #twiplomacy бол үл тоож болохгүй индэр болсныг харуулж байна. Харин үүнийг олон улсын түвшинд хүрэхэд чухал нөлөө үзүүлсэн шийдвэр гаргагч нь АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама бөгөөд “хөгжүүлэгч” нь тус улсын Ерөнхийлөгч асан Дональд Трамп гэгдэж байна (Most

influential world leaders 2020). Гэхдээ угшлыг нь 2011 онд АНУ-аас ОХУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл А. МакФол Twitter-ийг дипломат ажиллагааны хэрэгсэл болгон ашигласан анхдагчуудын нэг болсноор энэхүү платформыг орчин дипломат ажиллагааны албан ёсны хэрэглэгдэхүүн болоход хүргэсэн байна (П.Мягмардорж, 2019).

Гол санаа нь дижитал шилжилт ид өрнөж байгаа энэ цаг үед орчин үеийн дипломат ажиллагааны салбарласан утга гэж болох сүлжээний дипломат ажиллагааг дараагийн шатанд дэвшүүлэх аргачлал нь зөвхөн цахим хуудас байхаа больж Facebook, LinkedIn тэргүүтэй сувгуудаар дамжих болсны гол тоглогч нь Twitter болж гарч ирсэн юм. Учир нь 280 тэмдэгтийн хязгаартай, олон нийтэд товч бөгөөд тодорхой хүрэхэд хялбар зам байсан тул ийн хөгжсөн гэж судлаачид үздэг байна.

Технологийн салбарын тоглогчдын үйл ажиллагаа дэлхийн эдийн засагт томоохон үүрэгтэй салбаруудад нэвтэрч, хэрэглээ болж эхэлснээр өдгөө улс төр, цаашлаад үүнд суурилсан дипломат ажиллагаа ч мөн технологижиж эхэлжээ. Ийнхүү цахим хэлбэрээр улсынхаа бодлогыг олон нийтэд түгээх хандлага нэмэгдэж эхэлснээр олон нийт түгээмлээр ашигладаг сувгуудаар дамжуулан дипломат үйл ажиллагааг явуулах хувилбар шийдвэр гаргагчдын анхааралд өртөх болсон. Энэ нь зөвхөн цахим хуудас дахь албан мэдээлэл байхаа больж хэвлэл мэдээллийн дижитал түгээлтийн сувгийн контент болж

эхэлсэн төдийгүй цаашлан бид бүхний хувийн орон зайд нэвтэрч Twitter, Facebook, Instagram-д тархсаар байна.

2021 оны эхний хагас жилийн тооцооллоор Twitter 330 сая (statista.com) идэвхт хэрэглэгчтэй бөгөөд тэдний 206 сая нь өдөр болгон аккаунтаа шалгадаг (theverge.com). Энэ тоо бусад сошиал медиатай харьцуулахад хандалт өндөр хэвээр байгаагаас гаднын viral буюу олон нийтэд түгээмэлжүүлсэн АНУ-ын Ерөнхийлөгч асан Барак Обама (statista.com). Түүнчлэн дэлхийн томоохон удирдагчид twiplomacy-д идэвхтэй оролцож байгаа нь ач холбогдол нь буурахгүй байх үндэс болж байгааг онцлох хэрэгтэй.

В CW-ийн 2020 оны судалгаагаар 189 орны төр засгийн хамаарал бүхий дижитал дипломасид хамаарах төрийн тэргүүд болон гадаад хэргийн сайд нарын олон нийтийн нийгмийн сүлжээнд идэвхтэй байгаа нь (statista.com) НҮБ-ын гишүүн орнуудын 98 хувийг төлөөлж байна. Нийт 163 орон, 132 гадаад харилцааны сайд Twitter-т хувийн хуудастай бөгөөд 2020 оны зургаадугаар сарын 1-ний байдлаар төрийн өндөр албан тушаал эрхэлж буй хүмүүсийн 1089 хувийн болоод хувьсгалын Facebook хуудас байгаа бөгөөд 620 сая дагагч 8.7 сая жиргээг олон нийтэд хүргэжээ.

Сошиал платформууд дэлхий нийттэй шууд харилцах боломж олгож байгаа нь тухайн улсад өөрийн бодлогоо бүх хүрээнд шууд түгээх, улмаар таниулах үндэс болж байна. 2013 оны байдлаар дэлхийн

нийт Засгийн газрын $\frac{3}{4}$ нь Twitter-т нэгдсэн байжээ. Зургаан жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөнийг дээр дурдсантай харьцуулахад дижитал шилжилтийг үр дүнд нийгмийг сүлжээ томоохон байр суурьтай болсныг харж болно. Өдгөө энэ тоо улам өссөн. Цар тахалтай холбоотойгоор биечлэн явагдах нь давамгайл дипломат ажлууд цахим болохоос өөр аргагүйд хүрч, зайнаас гэх ойлголтыг улам бэхжүүлэхэд дэм болсон платформ нь сошиал буюу олон нийтийн нийгмийн сүлжээг ашиглах хэрэгцээг шаардлага болгосон юм. Тодруулбал, хамгийн залуу гэж алдаршсан Канадын Ерөнхий сайд Жастин Трудогийн эхнэр COVID-19 халдвар авсан тул Ерөнхий сайд өөрийгөө тусгаарлах шаардлагатай болсноо зарлан “Гэрээсээ ажиллах болсон тул товлолт уулзалтуудыг видео болон телеуулзалтууд хийх боллоо” хэмээн өөрийн албан ёсны хуудаснаа жиргэсэн.

Гар барихгүй, тэврэхгүй, нэгэндээ харц шидэлцэхгүй. Олныг цуглуулахгүй, олон талт уулзалт байхгүй. Ийм нийгмийг, дипломат ажиллагааг COVID-19 шаардах болсон. Энэ утгаараа дипломат ажиллагаа бүрэн дижиталчлалд шилжих сонголт л үлдэв (Twiplomacy study, 2020). Twiplomacy 2020 судалгаанд эшлэснээр хоёр талт, олон талд бүхий л уулзалт алсын зайны ямар нэг хэрэгслээр явах болж микрофон, интернэт (мэдээж хурдын хэлбэлзэл асуудал хэвээр байна) -ээр явж хоёр гаран жилийн хугацаанд биднийг “хоосон хонуулсангүй”. Ингэхдээ

оршил хэсэгт дурдсан hashtag diplomacy-гаар түлхүүр үгсийг ашиглаж байв.

Хүн амынхаа дийлэнхийг эртлэн дархлаажуулж эхэлсэн Израйлын Гадаад харилцааны сайд *“The #CoronaVirus had a dramatic impact on the role of #DigitalDiplomacy, which is now more important than ever before. Without physical spaces, many use #socialmedia to “socialize” and we’re taking advantage of that with engaging & relevant content that resonates with global audiences.”* буюу *“#Коронавирус #Дижиталдипломаси-д урд өмнө байгаагүй маш хүчтэй нөлөө үзүүллээ. Биечлэн уулзах нөхцөлгүй байгаа ийм үед олон хүн #socialmedia ашиглан нийгэмшиж буй нөхцөл байдлыг давуу тал болгон дэлхийн хүмүүст хүрч байна”* хэмээн жиргэсэн нь уламжлалт хүлээн авагчдаас гадна Twitter дэх шинэ зууны гэгдэж буй хүлээн авагчид Z үеийнхэнд хүрэх зорилго агуулсан хэмээн үзэж болно.

Энэ талбарт АНУ үргэлж тэргүүлэгч байр суурьтай ирсэн. Twitter-ийн хэмжээнд АНУ-ын Ерөнхийлөгч асан Дональд Трамп идэвхтэн жиргээч гэдгээрээ алдартай бөгөөд 2019 оны байдлаар тэр бээр хамгийн олон дагагчтай төрийн тэргүүн байсан төдийгүй өдөрт 22 мянган retweet-тэй авдаг байв.

Тэр бээр этгээд, хачирхалтай, өдөөн хатгасан жиргээгээрээ алдартай. Түүний идэвхтэн жиргээч байх, олон дагагчтай байх бас АНУ-ын эрх чөлөөт дуу хоолой гэх үзэл суртлыг түгээх том тайз болдог. Түүний дипломат бус жиргээнүүд дипломат

ажиллагааны шинэ чиг болж, улмаар Trump Diplomacy гэх ойлголтыг түгээж буй. Ингэснээр дэлхийн хамгийн том лидертэй олон нийтийн тавцанд үл ойлголцолд хүрэхгүйн тулд бусад орны удирдах албан тушаалтнууд түүнтэй маргалдахаас зайлсхийж, түүний хувийн гэж болох @realDonaldTrump хаягаар бус @POTUS хаягаар харилцахыг илүүд үздэг болжээ (twiplomacy.com). Бизнесийн салбараас төрийн салбарт орж ирсэн АНУ-ын одоогийн Ерөнхийлөгчийн twiplomacy уламжлалт дипломат ажиллагааг сөрөг дипломаси руу чиглүүлэх үр дагавар олонтоо гарсан. Гэвч түүний “зоригтой” жиргээнүүд АНУ-ын эрх ашгийг хамгаалж буй хэлбэр байж болохыг үгүйсгэх аргагүй.

Хүн амаараа дэлхийд тэргүүлэгч болсон, мөн хөгжиж буйгаас хөгжингүй болж буй Энэтхэг улсын Ерөнхий сайд Нариндра Моди мөн л twiplomacy-г хөгжүүлэгч лидер мөн. Тэр бээр дагагчдаараа дэлхийн төрийн тэргүүдийн гуравдугаарт ордог ч түүний оролцоо улсаа сурталчлахад төвлөрдөг. Тэр бээр улс төрч гэхээс илүүтэй нийгмийн төлөөлөгч гэх дүр төрх бүрдүүлэн дипломат дуу хоолой болж байгаа нь нэг талаар Махатма Гандигийн лигасиг үргэлжлүүлж буй мэт.

Дэлхийн улс төр, эдийн засагт томоохон үүрэгтэй гүрнүүдийн тэргүүлэгчид сошиал платформын чухал үүргийг хэдийн ойлгосон учир хэрэглээгч нь ч мөн бүрэн ашиглаж байна. Жишээлбэл, харьцангуй хаалттай гэгдэж ирсэн БНХАУ ч

нийгмийн сүлжээнд нэгдэж бодлогын хүрээнд мэдээллээ түгээж байна. Twitter-т 26 мянган дагагч, Facebook хуудас нь 1000 Like цуглуулж чадсан нь дээрх сошиал сүлжээг дотооддоо хаалттай байлгадаг улсын хувьд том амжилт. Өдгөө Хятад улс twiplomacy-д хүч түрэн орж ирж байгаа ч өөрсдийн платформоор дамжуулах сонирхолтой байгаа юм. Тэд WeChat сошиал платформоо өргөжүүлэх замаар хэрэглэгчдийг нэмэгдүүлэх, улмаар тэнд дурдагдаж буй зүйлсийг дэлхий нийтэд хүргэх зорилготой ажиллаж байна. Ингээд үзвэл дижитал шилжилт улс орны бодлого тодорхойлогчдын хувьд үзэл санаагаа танилцуулах, тулгах чухал суваг болж байгаа учраас бүхий л сувгийг бүрэн бололцоогоор ашиглах нь тухайн улсын том бодлогын томоохон хэсэг болж байна. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд LinkedIn, Pinterest, Snapchat, тэр ч бүү хэл Youtube, TikTok хүч түрэн орж ирж байна. Чиглэл бүрээр, бүх насныхныг хамруулах бодлого ийн хэрэгжиж байгаа нь Аж үйлдвэрийн шинэ хувьсгалын хязгааргүй тэлэлтийг илэрхийлж байна. Дэлхийн нийт хүн амын бүтэц хөдөлгөөнгүй хэлбэрт шилжиж байна. Дэлхийн хүн амын одоогоор 7.7 тэрбум байгаа бөгөөд энэ зууны сүүлээр 11 тэрбумд хүрэх тооцоо гарсан (ourworldindata.org). Тэр үед дэлхий нийт 11 тэрбум хүрсэн бүтэц бий болгох ёстой болно. Харин үүнд дижиталчлал, AI, IT тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Том гүрнүүд ч үүнийг мэдэж буй. Иймээс ч энэ чиглэлд хөрөнгө оруулалт хийж буйг дэлхийн

эдийн засгийн хоёр том тоглогч болох АНУ, Хятад, шинээр элсэгч гуравдагч хүч Энэтхэг хийх юм. Харин эдгээр улстай хөрш, түнш Монгол одоогийн хөгжлийн хаана явна вэ? Энэ бүхэн Монгол шиг “жигжиг” улсад хэрхэн нөлөөлөх бол гэдэг нь зайлшгүй судалж үзэх асуудал юм.

Сошиал медиа бол өнөө цагийн радио. The Digital Diplomacy Handbook-ийн зохиолч Антонио Деруда “Сошиал медиагийн үнэт зүйл бол зөвхөн шинэ хүмүүст хүрэх боломж буй засгийн газрууд болон иргэд хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх” гэж тодорхойлжээ. Хэвлэх үйлдвэр, телеграф, телефон, телевиз зэрэг теле мэдээллийн харилцаа хэдийн бий болсон байсан учир Олон нийтийн харилцааны түүхэнд интернэт эхний хувьсгал биш боловч шууд харилцааг бий болгосон анхдагч хэрэгсэл гэж ойлгож болно (Shirky Clay, 2019). Гэхдээ хүн төрөлхтний өнөөгийн мэдэх цахим процесс интернэт бий болсон цагаас хойш байр сууриа тасралтгүй бататгаж ирсэн (Mongolian Economy, 2016). Энэ бол олон нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх хүртэл олон арван жил зарцуулж ирсэн явц. НҮБ-ын харьяа Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) 2019 онд дэлхийн хүн амын 50 хувь нь интернэт холбогдсон байх талаар таамаг гаргаж байсан.


И-мэйл илгээхээс хэтрэхгүй байсан цахим хэрэглээ өдгөө дижитал шилжилт болон хувьсаж AI (хиймэл оюун), Blockchain, VR (вир-

туал реалити), AR (augmented reality), IoT (юмсын/зүйлсийн интернэт), дроны технологи зэргээр салбарлан хөгжиж байна. Бүхий л салбарт хүч түрэн орж ирж буй дижитал технологиудын тусламжтайгаар өнөөдөр дэлхийн 7.7 тэрбум хүн энэхүү шилжилт өөрөөр хэлбэл, хувьсгалд нэгдэхээс өөр замгүй болж байна.

IoT-ийн ирээдүйг наашлуулж буй хямд мэдрэгч, супер хурдан сүлжээ гэсэн голлох хоёр технологи хурдтай хөгжиж байна. Gartner судалгааны группийн тооцоолсноор мэдрэгчтэй холбогдсон төхөөрөмжийн тоо дэлхийн хэмжээнд 2017 онд 8.4 тэрбум байснаас 2020 онд

20.4 тэрбум болж огцом өсөх таамаг гаргасан. Хоёр дахь нөхцөлдүүлэгч нь 5G сүлжээ. Энэ мэтээр дижитал шилжилтийн хурд өссөөр.

Дижитал хувьслын гол зорилго нь технологи хүчийг нэмэгдүүлэх гэх бус хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй бодлогыг баримтлах явдал (unread.today). Гэхдээ дижитал шилжилтээс бий болж буй технологиудын хэрэглээг хэрхэн зохицуулах талаарх хууль эрх зүйн орчин хэрхэн бүрэлдэх талаар дэлхий нийт одоо ч шийдэл олоогүй байгаа нь цахим аюулгүй байдлын асуудлыг хөндөх сэдэв болгож байна (The Economist, 2019).



Зураг 2. Монгол Улсын Олон нийтийн нийгмийн сүлжээний хэрэглээ, 2021 оны гуравдугаар улирал. Эх сурвалж: Statcounter.com.

Дээрх статистикаас харвал Монгол Улсад Facebook хандалт ихтэй бөгөөд олон улсын twiplomasуд тэргүүлэх байр суурьтай Twitter өмнөх жилтэй харьцуулахад 25

орчим хувийн өсөлттэй орж ирсэн байгаа юм. 2019 оны байдлаар монголчуудын социал медиа хэрэглээний дөрөвдүгээрт бичигдэж байсан Twitter энэ жилийн есдүгээр

сарын статистик үзүүлэлтээр хоёр дахь чухал хэрэгсэл болж өөрчлөгджээ.

МУ-ын Ерөнхийлөгч асан Х.Баттулга Twitter-т манай улсын хамгийн олон дагагчтай улстөрч. Тэр бээр 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үе гэхэд Facebook-т 434 мянган Like бүхий цахим хуудастай. Инстаграмд мөн 40 мянган дагагчтай. Энэ нь “Монгол Ялна” гэх уриан дор буюу Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин өрсөлдөж байх үед эрчимтэй нэмэгдсэн байгаа юм. Хэдийгээр манай улсын Ерөнхийлөгчийн twitter хуудас хамгийн олон дагагчтай гэгддэг боловч эдгээрийн дийлэнх олонх нь бот буюу хуурамч хаяг байх магадлалтай.

Тэгвэл тухайн үед МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Twitter хуудаснаа 32 мянган дагагч, Facebook-т 147 мянган Like бүхий хуудастай (PM Office 1K) бол Инстаграмд өөрт хамаарах албан хаяггүй байв.

Харьцуулсан ажиглалтаас харахад АНУ болон МУ-ын Элчид сайд нар twiplomacy-ийн сувгуудыг харьцангуй сайн ашиглаж байгаа бол Ерөнхийлөгч асан Х.Баттулга АНУ-ын Ерөнхийлөгчтэй харьцуулахад дипломат харилцаа түгээх зорилго бүхий жиргээ хийдэггүй бөгөөд 2017 оны 11 сарын 30-ны жиргээгээ Pinned хэвээр байлгаж байгаа нь мэдээллийн эргэлт муу хийж байгааг илтгэж байгаа юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хамруулан судалсан төрийн төлөөллүүдийн жиргээ хаягууд дунд гадаад улсын төлөөллүүд цахим хуудас, суваг бүрээ албажуулсан

(verified) байгаа бол манай улсад энэ талаарх ойлголт түгээмэл бус, улмаар verified аккаунтуудын тоо тухайлбал, АНУ-тай харьцуулахад маш бага байна.

Харин цар тахлын үед Монгол Улс дахь twiplomacy хаана төвлөрч байсныг судалж үзвэл эрүүл мэндийн салбар, Улсын Онцгой комисс тэргүүтэй байгууллагууд түлхүү оролцоотой гэсэн таамаг батлагдсан юм. Түүнчлэн гадаадад гацсан иргэдийн нэгдэл сошиал медиа ашиглан бүлэг үүсгэн эсэргүүцлээ илэрхийлж байсан нь иргэний дипломасигийн нэг хэлбэр болж орж ирсэн. Энэ нь цаашлаад Төрийн гурван өндөрлөгт чиглэсэн хариулт авах акц болж өргөжиж байв (<https://asia.fes.de/news/social-media-and-public-discourse-in-mongolia>).

Цахим шилжилт гэдэг зүйл зөвхөн төрийн институцид бий болсноор хэрэгждэг ойлголт биш. Үүнд улс нийтээрээ оролцоотой байж бүрэн утгаараа шилжилт болно. Гэтэл манай улсын хувьд хүн амын дийлэнх нийслэлд төвлөрсөн тэдгээрийн дийлэнх интернэтэд холбогдсон гэж буй ч хэрэглээний судалгаанд суурилсан дүнгээр харьцуулалт хангалтгүй байна. Иргэдийн дийлэнх цахим банк ашигладаг боловч цахимаар татварт төлөлтөд оролцож буй хувь хэмжээ хангалтгүй байна. Интернэт ашиглан худалдан авалтын баримт бүртгүүлж буй боловч виз олголттой холбоотой мэдээлэлд нэвтрэх чадавх хомс хэвээр. Ийн үзэхэд олон улсад танил болсон дижитал шилжилтийн технологийн хэрэглээний дадал

манай улсад нутагшиж амжаагүй байгааг илтгэх зүйл бол цахим үнэмлэх. Эдгээрээс үзвэл манай улс дижитал дипломасийг зохих утгаар гэхээс илүү иргэний нийгмийн түвшинд л ашиглаж байна. Тэд гадаад харилцааг цахим уулзалт, утсаар ярих гэсэн уламжлалт арга барилаас “хальж” ашиглахгүй байгаа нь харагдаж байна.

Дижитал үндэстэн боллоо гэсэн одоогийн Ерөнхий сайдын тунхаглал цагаа олоогүй мэдэгдэл байлаа гэж үзэж болно. Учир нь бидний өмнө нээлттэй буй, зөвхөн 3.3 сая хүнд бус дэлхийн бусад иргэнд хүрэх боломжтой нээлттэй платформ ашиглаж мэдэхгүй байна. Twiplomacy-г дэлхийн томоохон орнуудын хэмжээнд хүрч ашиглах стратеги дадал, туршлага хэдий байхгүй ч тийш анхаарлаа хандуулах цаг нэгэнт болжээ. Тэр тусмаа цар тахал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болж буй энэ цаг үед олон нийтийн цахим сүлжээг бодлогын түвшинд авч үзэхээс өөр аргагүй. Учир нь дэлхийн лидерүүд үүнийг ойлгоод хэдийн 10 гаруй жилийг үзчихээд байна.

Дипломат ажиллагаанд оролцогч субъектүүд өргөжиж, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, мэдээлэл-холбооны технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон нь сонгодог буюу уламжлалт дипломат ажиллагаа дангаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болов. Мөн дижитал дипломаси, дижитал секретариат, дижитал элчин сайдын яам, дижитал элчин

сайд, цахим эрх чөлөө буй болов. Facebook, Twitter дипломаси улс орнуудын иргэдийн санаа бодол, сонгуулийн үйл явцад хүчтэй нөлөө үзүүлж эхлэв. Өнгөт хувьсгалын гол хөдөлгүүр нь сошиал медиа юм (Д.Уламбаяр, 2019 он).

Дүгнэлт. Дижитал шилжилтийг зөвхөн олон нийтийг нийгмийн сүлжээ гэж ойлгож болохгүй. Гэхдээ энэ платформ маш олон хүнд асар хурдтай хүрдэг контент түгээлтийн хэрэгсэл болж хувирч байна.

Twiplomacy буюу цахим дипломат ажиллагаа, зарим талаар жиргээний дипломаси гэдэг ойлголт олон улсын түвшинд дипломат ажиллагаанд хэдийн нэвтэрсэн бөгөөд их гүрнүүдийн бодлого тодорхойлогчид, шийдвэр гаргагчид дэлхий нийтэд хүрэх гарц гэдгийг хүлээн зөвшөөрөөд байна. Дижитал шилжилтийн хурд ч мөн тэдэнд цаг хэмнэх, зардалаа багасгах, хамгийн гол нь шууд харилцах боломжийг бүрдүүлж байна.

Харин энэ үйл явц манайх шиг жижиг оронд эдийн засгийн үр ашгаа илүүтэй өгөх ёстой боловч гадаад бодлого гэхээс илүүтэй улс төр хийх хүрээнд түлхүү ашиглагдаж байна. Гадаад харилцааг дэлгэрүүлэх бус, дотоод улс төржилтийн талбар болж байгаа нь харагдлаа. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчид, харилцагчид болон гадаад харилцааны чухал түншүүдэд сөрөг мэдээлэл болж хүрэх эрсдэлтэй гэдгийг Монгол Улсад олон нийтийн нийгмийн сүлжээг ашиглаж буй шийдвэр гаргагчид бүрэн ухамсарлахгүй байгааг илтгэж байна.

Digital report судалгаанд монгол хүн өдөрт 77 минутыг олон нийтийн нийгмийн сүлжээ, тэр дундаа Facebook-т зарцуулж байна гэсэн нь 2.2 сая (нийт хүн амын 70 хувь) хүний сошиал хэрэглээг илтгэж байсан бол 2021 оны есдүгээр сарын байдлаар дээрх тоо 2.95 сая болж өссөн. Энэ бол нийт монголчуудын 89.9 хувь нь Facebook-чид гэсэн үг. Олон нийтийн нийгмийн сүлжээний хэрэглээ twiplomacy ямар том тайз байж болохыг илтгэж байна.

Харин Монгол Улсад twiplomacy олон улсад ойлгогдож буй хэлбэрээрээ өрнөхгүй байгаад манай улс дахь дижитал диплома-сигийн асар том сул тал оршиж байгаа юм. Нөгөө талаар манай улсад энэ талын суурь судалгаа хомс, нийтлэл, блоогоос хэтрэхгүй хэмжээнд мөн судалдаг тоотой хэдэн эрдэмтдийн үзэл бодол төдий байна. Монгол Улсад цахимжилтыг вэбсайт гэж үзсэн хэвээр байгаа энэ үед #дигиталдипломаси буюу цахим дипломат ажиллагааг бодлогын хэмжээнд хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй бий.

Эшлэл

1. Corneliu Bjola & Marcus Holmes. Digital diplomacy: Theory and Practice. 2015.
2. Corneliu Bjola & Marcus Holmes. Digital diplomacy: Theory and Practice. 2015.
3. <https://twiplomacy.com/ranking/the-50-most-influential-world-leaders-in-2019/2020>
4. Business.mn сэтгүүлийн цахим хуудас. “Дижитал шилжилт эцсийн зогсоол биш, тасралтгүй аялал” ярилцлага.
5. Mongolian Economy, 2016.02, Маргааш юу болох вэ? Нэвтрүүлгийн I хэсэг.
6. Most influential world leaders 2020.
7. Орчин үеийн дипломат ажиллагаа, ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн ахлах багш П.Мягмардорж, лекц 2019 он.
8. <https://www.statista.com/statistics/282087/number-of-monthly-active-twitter-users/>
9. <https://www.theverge.com/2019/2/7/18213567/twitter-to-stop-sharing-mau-as-users-decline-q4-2018-earning>
10. <https://www.statista.com/statistics/242606/number-of-active-twitter-users-in-selected-countries/>
11. [https://www.statista.com/statistics/242606/number-of-active-twitter-users-in-selected-countries/Burson Cohn & Wolfe, Twiplomacy study 2020](https://www.statista.com/statistics/242606/number-of-active-twitter-users-in-selected-countries/Burson-Cohn-&Wolfe-Twiplomacy-study-2020)
12. Twiplomacy study 2020
13. <https://twiplomacy.com/blog/twiplomacy-study-2018/>
14. <https://ourworldindata.org/age-structure>
15. Shirky, Clay. “How Cell Phones, Twitter, Facebook Can Make History.” TED Talks. Youtube, 16 June 2009. Practicing successful twitter public diplomacy: a model and case study of u.s. efforts in Venezuela Erika A. Yepsen July 2012 Figueroa Press Los Angeles, www.uscpublicdiplomacy.org
16. “Mongolian Economy” сэтгүүл, 2016.02, Маргааш юу болох вэ? Нэвтрүүлгийн 1-р хэсэг
17. www.unread.today. Дижитал хувьгал гэж юу вэ?
18. “The Economist”, World in 2019, Монгол хувилбар. хуудас 18.
19. Д.Уламбаяр. Дижиталчлалын үйл явц: Сорилт ба боломж. 2019.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Antonio Deruda. 2014. The Digital Diplomacy Handbook
2. Corneliu Bjola & Marcus Holmes. 2015. Digital Diplomacy: Theory and Practice. London & New York.
3. Klaus Schwab. 2016. The Fourth Industrial Revolution.
4. Параг Ханна. 2016. Холболтын газар зүй. Орчуулагдсан УБ.
5. Ilan Manor. 2019. The Digitalization of Public Diplomacy. Oxford
6. Burson Cohn & Wolfe. 2019. World Leaders on Facebook, Fourth edition.
7. Д.Уламбаяр. 2019. Дижиталчлалын үйл явц: Сорилт ба боломж. УБ
8. Д.Уламбаяр. 2019. Монгол Улс төвийг сахисан нутаг дэвсгэр биш
9. Mongolian Economy magazine. 2016-2020.
10. Philip Seib, Contributor to www.opencanada.org. 2021. Twiplomacy: Worth praising, but with caution.
11. Simon Kemp. 2020. Digital 2020. Mongolia Report 12.
12. <https://www.orfonline.org/research/twitter-diplomacy-a-brief-analysis-60462/?fbclid=IwAR3PX2op0zkYUXchQuc1IVxuR2YtZ1I9UVDM1VI5FnsPkn126kS0ZvFCBuE>
13. https://www.nytimes.com/2014/02/05/world/middleeast/in-the-scripted-world-of-diplomacy-a-burst-of-tweets.html?fbclid=IwAR1pcv8FKQjpT1JWltCQ_mWkQDk8YSWr1arhbsNrT-TVQd3NRyffUDeyahA
14. <https://blogs.ubc.ca/mongolia/2018/ub-dialogue-2018/>.
15. Орчин үеийн дипломат ажиллагаа, ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн ахлах багш П.Мягмардорж, лекц, 2019
16. Бүтээлч үндэстэн төсөл: Маргааш юу болох вэ? Нэвтрүүлэг 1-р хэсэг
17. <http://www.cabinet.gov.mn>
18. www.weforum.org
19. www.twitter.com, @USAmbMongolia, @OtgonbayarY, @realDonaldTrump
20. www.facebook.com
21. www.twiplomacy.com
22. www.statista.com
23. www.socialbakers.com
24. www.statcounter.com
25. www.diplomacydata.com
26. <http://www.mongolembassy.com>
27. www.1212.mn
28. TEDx talks on digital diplomacy

Summary

Daily working hours of eight, mass production, that drove the world economy in the early until mid XX century, now in the era of new industrial revolution, became a segment of the recent past. Although the concept visualized the XX century both economically and socially as well as the energy of the work force, a definitive change was imminent in the era we now describe as Industrial Revolution IV. Countries that were the Power House of the world's politics, economy and most importantly decision-making process met with a different faith since the new millennial. So many changes have occurred in the way we walk, talk and communicate. Likewise, international relations, more so in diplomatic relations, made its shift into the world of digitalization. It has become more civil based in way that you could interpret it as civil diplomacy thanks to increased usage of social media. The continuous changes that have been made since its first "Hello" to the social media platform, the diplomacy could never turn back to how things were conducted before going ONLINE. For that reason, hashtag diplomacy or TWIPLOMACY, gaining activeness in the early 2000s, was officially introduced to the public to engage.